



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.06.03-06.07

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Холбооны Нөөцийн Банк богино хугацааны хүүний түвшинг бууруулах хүлээлт үүсгэснээр хувьцааны ханш өсч 5-р сарын алдагдлыг нөхөв.

S&P 500 индексийн сагсанд багтаж буй бүх салбар өсөлттэй байсан ба харьцангуй жижиг материалын салбар хамгийн ихээр өсжээ. Газрын тосны ханшийн уналттай холбоотойгоор эрчим хүчний салбар харьцангуй бага өсөлттэй байсан ба үл хөдлөх хөрөнгө болон аж ахуйн салбар мөн өсөлт багатай байв. Antitrust буюу монополийн эсрэг байгууллага Apple, Amazon, Facebook болон Alphabet(Google) компаниудыг шалгахаар бэлтгэж байгаагаар зарласнаар томоохон технологийн компаниудын хувьцаа 7 хоногийн эхэнд огцом буурсан. АНУ-ын төлөөлөгдчдийн танхимын шүүхийн хороо мөн дижитал зах зээлд шалгалт хийх гэж байгаагаар мэдэгджээ.

Европ: Худалдааны маргаан олон улсын эдийн засагт нөлөөлвөл АНУ-ын төв банк болон Европын төв банк хоёул бодлогын хүүгээ буулгаж зохицуулалт хийх хандлагатай байгаа нь хувьцааны зах зээлд эерэгээр нөлөөлөв.

Европын холбооны гэрээ, хэлцлийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй Европын комисс нь Итали улстай хуулийн дагуу маргалдах саналыг тавьсан нь байдлыг улам хурцадгах магадлалтай байна. Итали улс нь Европын холбооны зээлийн хязгаарыг өнгөрсөн жил давсан ба 2019, 2020 онд мөн зөрчиж давах төлөвтэй байна. Итали зээлийн хэмжээгээ бууруулах арга хэмжээ хангалттай авахгүй байгаа бөгөөд 2020 онд зээл нь ДНБ-ны 135%-тай тэнцэх хэмжээнд өсөх хандлагатай байна. Еврозонын улсууд өрийн хэмжээг ДНБ-ын 60%-с дээшгүй хэмжээнд барих шаардлагатай байдаг билээ.

Япон: Дэлхийн банк Японы 2019 оны өсөлтийн таамаглалаа 0.9%-с 0.8% болгон бууруулсан ч хувьцааны ханш өсөлттэй байв. АНУ-БНХАУ хоорондын худалдааны маргаанаас хамааралтайгаар Японы эдийн засаг эмзэг байгааг тайландаа дурдсан бөгөөд ялангуяа БНХАУ дахь экспорт сул байгааг онцолсон байна. Мөн 10-р сард нэмэгдсэн өртгийн татвар нэмэх төлөвтэй байгаа нь эдийн засгийг улам удаашруулах эрсдэлтэй байна. Япон улсын ажилгүйдлийн түвшин бага, ажиллах хүчний оролцоо өсч байгаа болон үйлчилгээний салбар эрүүл байгааг мөн тэд онцолжээ. Дэлхийн банкаас Япон улсын 2020 оны өсөлтийн таамгийг 0.7%-д хэвээр үлдээсэн байна.

БНХАУ: АНУ БНХАУ хоорондын худалдааны маргаан улам хүндрэх хандлагатай байгаа ба БНХАУ-ын индексүүд 4 сарын доод түвшиндээ хүрээд байна.

Өнгөрсөн 7 хоногт БНХАУ-ын засгийн газар Ford Motors компанийн дотоод дахь хамтарсан үйлдвэрийг 162.8 сая юан буюу 23.6 сая ам.доллараар торгосон бол Huawei Technologies-ын БНХАУ дахь салбарт хүргэх шууданд асуудал үүсгэсэн байж болзошгүй шалтгаанаар FedEx компанийг шалгаж байгаагаар зарласан юм.

Эх сурвалж: Troweprice.com, BloombergTv.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,566.93	-2.15% ▼
Dow Jones	АНУ	25,983.94	4.71% ▲
S&P 500	АНУ	2,873.34	4.41% ▲
Nasdaq	АНУ	7,742.10	3.88% ▲
S&P/TSX	Канад	16,230.96	1.21% ▲
FTSE 100	Их Британи	7,331.94	2.38% ▲
S&P/ASX 200	Австрали	6,443.90	0.73% ▲
Nikkei 225	Япон	20,884.71	1.38% ▲
Hang Seng	Хонг Конг	26,965.28	0.24% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.17
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	99.85
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.36
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.32
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.27
DBM' 2023	USD	7.250%	102.42
TDBM' 2020	USD	9.375%	103.37

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.412	-0.02 ▼
Libor 3M	2.451	-0.05 ▼
Libor 6M	2.372	-0.14 ▼
Libor 1YR	2.346	-0.16 ▼
US 2YR Bond	1.888	-0.02 ▼
US 3YR Bond	1.858	0.00 ▲
US 5YR Bond	1.889	-0.01 ▼
US 10YR Bond	2.116	-0.01 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.05.31	Өөрчлөлт
USD	2,652.13	0.10% ▲
CNY	383.83	0.01% ▲
EUR	2,986.43	1.16% ▲
RUB	40.78	0.57% ▲
KRW	2.24	0.90% ▲
JPY	24.45	0.37% ▲
CAD	1,986.54	1.44% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,340.86	2.70% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.02	2.92% ▲
Зэс	USD/lb.	262.75	-0.47% ▼
Нүүрс	USD/MT	75.00	-2.66% ▼
WTI газрын тос	USD/bbl.	53.99	0.92% ▲
Brent газрын тос	USD/bbl.	63.29	-1.86% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.34	-4.49% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. IV	7.00%
Бодлогын хүү	2019. IV	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. IV	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. IV	11.83%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. IV	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. IV	17.11%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. IV	10.57%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 44 компанийн 515.5 сая төгрөгийн 4,079,270 ширхэг хувьцаа арилжигдав.

“Монгол савхи” /UYN/ компанийн хувьцаа 15.26%-аар буюу хамгийн ихээр өсөж 605.14 төгрөгт хүрч хаагдсан бол “Шивээ овоо” /SHV/ компанийн хувьцаа 13.51%-аар буурч 1600.0 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

6-р сарын 7-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,342.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,566.93 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.15%-аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	515.5
Зах зээлийн үнэлгээ	2,342,471.0

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,566.93	-2.15% ▼
MSE I индекс	9,045.31	-3.11% ▼
MSE II индекс	7,843.67	0.47% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	2,078,034	126,194,704
Монос хүнс	1,273,372	91,407,243
Мандал даатгал	13,576	70,104,185
АПУ	89,254	50,933,832
Стандарт ноос	152,624	42,734,720

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	605.14	15.26% ▲
Ариг гал	3,600	12.50% ▲
Женко тур бюро	71.5	8.32% ▲
Жуулчин дюти фрий	108,400	7.97% ▲
Монгол базальт	289.97	7.40% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Шивээ овоо	1,600	-13.51% ▼
Хэрлэн хивс	68	-12.82% ▼
Стандарт агрикалчер групп	195	-11.36% ▼
Мик холдинг	12,500	-10.65% ▼
Монгол шевро	2,000	-10.19% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал ХХК	211,332,046
БиДиСек ХК	162,146,210
Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	144,014,722
Бумбат-Алтай ХХК	62,068,298
Стандарт инвестмент ХХК	58,690,703

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	566.00	602,327
Таван толгой	6,870.00	361,810
МИК	12,500.00	258,867
Говь	282.75	220,577
Сүү	195.99	67,421

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.05.03-ны дотор
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Инвекор ББСБ” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 2019.06.10-нд эхэлнэ

СЗХ-ны даргын 2019 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 1/2369 тоот албан тушаалаар “Инвекор ББСБ” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсонтой холбогдуулан хөрөнгө оруулагчид үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх 6 дугаар сарын 04-нд үүслээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдлээ

БНСУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Райнос Ассет Менежмент Монгол” ХХК Монгол улсын үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахаар нээлтээ хийв. Арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн нээж үг хэллээ.

Тус компани нь Монгол улсад хөрөнгө оруулалтын менежмент, хөрөнгө оруулалтын сан байгуулан үйл ажиллагаагаа эрхэлж буй анхны гадаадын компани юм.

Энэ үйл явдал нь сүүлийн жилүүдэд СЗХ-ноос санхүү, хөрөнгийн зах зээлд хэрэгжүүлсэн бодлого зөв байж, зах зээлийн тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжсэнийг, улмаар дотоод гадаадын хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөл бүрдэж эхэлснийг нотолсон үйл явдал боллоо.

БНСУ-ын “Rhinos Asset Management” компани 2017 онд Монголын Хөрөнгийн биржийн IPO-д хөрөнгө оруулсан анхны гадаад компани болж байлаа. Тэд “ЛэндМН” ХК-д 70 тэрбум төгрөгийн стратегийн хөрөнгө оруулалт хийж, Монголын санхүүгийн орчинд финтек технологид итгэл авчрах томоохон алхамыг эхлүүлсэн юм.

Хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээл дэх Азийн томоохон тоглогч энэхүү компанийн салбар “Райнос Ассет Менежмент Монгол” ХХК нь 10 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй хаалттай бондын санхүүжилтийн гэрээг “Анд системс”-тэй байгуулснаар манай улс дахь салбарын үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүллээ. “Анд системс” бол Монголын тэргүүлэгч финтек компани “ЛэндМН”-ийн толгой компани гэдгийг санхүүгийн хүрээнийхэн төдийгүй иргэд мэддэг болсон.

“ЛэндМН” нь “Райнос Ассет Менежмент Монгол” ХХК, “Mirae Asset Securities” үнэт цаасны компанитай дөрвөн сая ам.долларын итгэлцлийн программд хамтарч ажиллахаар болсон нь Солонгосын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааны бас нэг алхам болов.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Хөрөнгөөр баталгаажсан 7 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд гарлаа

2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Капитрон банк, Жи Мобайл ХХК-тай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хамтын ажиллагааг эхлүүлэх гэрээ байгууллаа. Гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн нээж үг хэлэв.

Санхүүгийн зохицуулах хороо 2018-2021 оны стратеги төлөвлөгөөндөө “Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, санхүүгийн зах зээлийг тэлэх” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Хорооны 2019 оны тавдугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар анхны арилжааны шинжтэй бүтцийн бүтээгдэхүүн болох “Жимобайл вексель” ТУЗ ХХК-д 7.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгосон.

Арилжааны банкуудаас хөрөнгийн зах зээлд оролцож, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж буй анхны банк нь “Капитрон банк” ХХК боллоо.

Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлагаас үзэхэд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар дамжуулан орлогын дахин хуваарилалт хийж, иргэдийг орон сууцжуулах, хөрөнгийн зах зээлд хөрвөх чадвар сайтай, эрсдэлгүй бүтээгдэхүүнийг арилжаалдаг.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



“Мост финтек” компани нээлттэй хувьцаат компани боллоо

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/25 тоот тушаалаар “Мост Финтек” ХХК-ийн нийт 466,716,642 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн III ангилалд бүртгэснийг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцэж, 126 тоот тогтоолоор нийт гаргасан хувьцааны 22.23 хувь буюу 103,766,700 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд МХБ-ийн “Арилжааны журам”-ын дагуу тогтоосон үнийн аргаар санал болгон арилжаалахыг зөвшөөрлөө.

Санал болгон худалдах хувьцааны 11.12 хувь буюу 51.8 сая ширхгийг тус бүрийг нь 47 төгрөгөөр стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн 11.12 хувь буюу 51.8 сая ширхгийг тус бүрийг нь 47 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдах замаар нийт 4.8 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Тус компанийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс давсан тохиолдолд нэмж 11.1 хувь буюу 51,649,942 ширхэг хувьцаа тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 47 төгрөгөөр худалдаалахыг зөвшөөрсөн байна.

Энэхүү хувьцааны андеррайтераар “Эс Жи Капитал ҮЦК” ХХК ажиллаж байгаа ба аудитын дүгнэлтийг “Хүлэгт Хүннү Аудит” ХХК, хууль зүйн дүгнэлтийг “Батбаяр энд Партнерс” ХХН, хөрөнгийн үнэлгээг “Координат Аудит” ХХК тус тус үзүүлсэн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ, БНХАУ газрын ховор элементийн асуудлаар тохиролцож чадахгүй байна

АНУ, БНХАУ угаалгын машинаас эхлээд цэргийн хэрэгсэлд хүртэл ашиглагддаг газрын ховор элементийн худалдааны асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй хэвээр байна. АНУ-ын Худалдааны яамны мягмар гарагт гаргасан албан мэдэгдэлд "АНУ газрын ховор элементийн татан авалтыг тасалдуулахгүйн тулд өмнө байгаагүй шаардлагатай арга хэмжээ авахаа амласан" байна.

Үүнд 17 ховор элемент багтаж байгаагийн дийлэнхийг БНХАУ-аас импортлодог ажээ. Үүнээс өмнө БНХАУ-ын Эдийн засгийн бодлого төлөвлөлтийн газар газрын ховор элементийн экспортын хяналтыг чангатгахаар төлөвлөж байгаагаа мэдэгдсэн юм. БНХАУ-ын Төрийн мэдээллийн агентлаг газрын ховор элемент худалдааны чухал зэвсэг болох боломжтойг онцолж байна.

Тус улс олон улсын хэмжээнд энэ төрлийн бүтээгдэхүүний гарцын 70 гаруй хувийг хангадаг гэсэн тоо баримт бий. Боловсруулсан бүтээгдэхүүний нийлүүлэлтээр тооцвол улам ч илүү өндөр хувийг эзэлж байна.

Хэрэв БНХАУ экспортоо хязгаарлавал худалдааны маргаан улам даамжрах эрсдэлтэй. АНУ БНХАУ-ын "Huawei"-д хориг тавьсан бол БНХАУ АНУ-ыг зорих асуудлаар иргэддээ санамж гаргасан юм.

Хэдийгээр худалдааны маргаан даамжирч байгаа ч АНУ-ын "Boeing" компани БНХАУ-ын авиа компаниудад 100 орчим нисэх онгоц худалдах томоохон хэлэлцээ хийж байгаа талаар эх сурвалж мэдээллээ. Үүнд "787 Dreamliners" болон хол зай туулах чадвартай "777X" шинэ загварын онгоц багтсан байна.

Ийнхүү АНУ-ийн компаниуд хүнд нөхцөлд ч хэлэлцээр хийх оролдлого хийж байгаа БНХАУ ямар чухал зах зээл гэдгийн баталгаа гэж ойлгохоор байна. "Boeing" компани БНХАУ-ын компаниудад таатай нөхцөл санал болгож байгаа ч тус улсын нисэх тээврийн компаниуд Засгийн газрын албан ёсны зөвлөмжийг хүлээж байгаа аж. Энэ нь хэлцэл урагшлахад саад болж байна гэж "Boeing" мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

"Terracom limited" нэмэлт 25.9 сая энгийн хувьцаа гаргаж, 20.2 сая ам.доллар татан төвлөрүүлэв

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Terracom Limited" компани энгийн хувьцаа гаргаж, 20.2 сая ам.доллар татан төвлөрүүлснээ зарлалаа.

Хувьцааны захиалгыг тавдугаар сарын 10-29-ний хооронд авсан байна. Нэгжийн үнийг 0.58 ам.долларын гэж санал болгосон байна. 34.9 сая ширхэг хувьцааны захиалга хүлээн авснаас 25.9 сая нь биелжээ. "Terracom" компанийн одоо арилжаанд байгаа энгийн хувьцаатай ижил түвшинд байх шинээр гаргасан хувьцаа зургаадугаар сарын зургааны өдрөөс Австралийн Хөрөнгийн биржид арилжаалагдаж эхлэх юм байна.

"Terracom" компани Монголд Өмнөговь аймгийн нутагт байрлах Баруун Ноён уул, "Huvguun East", "Mid-Gobi" уурхайнуудын тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Тус компани Монгол дахь орддоо нэмэлт хайгуул хийж, олборлолтын хэмжээг жилийн гурван сая тонн болгохоор зорьж байгаа аж. Баруун Ноён уул орд нь Өмнөговь аймгийн Ноён суманд байрладаг, жорк стандартаар тогтоосноор 15.26 сая тонн нүүрсний нөөцтэй юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

Оны эхний саруудад буураад байсан алт тушаалт V сард эргэн өслөө

2019 оны эхний таван сард Монголбанк нийт 4.2 тонн алт худалдаж авсан байна. Тавдугаар сард нэг тонн 877 кг алт худалдаж авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 200 гаруй кг-аар өссөн үзүүлэлт болжээ.

Хэдий тийм боловч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой хуулийн тодорхойгүй байдлаас үүдэж оны эхний гурван сард худалдаж авсан алтны хэмжээ 80 гаруй хувиар огцом буурсан аж. Үүнтэй холбоотойгоор алт худалдан авалтын нийт дүн оны эхний таван сард өмнөх оноос 800 орчим кг-аар бага байна. Хууль батлагдсаны дараа алт тушаалт эргээд өслөө.

Монголбанк энэ онд 20 гаруй тонн алт худалдаж авах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Алтны үнэ өндөр үед Төв банканд тушаах алтны хэмжээ өсөх хандлагатай байдаг.

Лондоны Үнэт металлын биржид алтны спот ханш 1312 ам.доллар хүрч сүүлийн хоёр сар гаруйн дээд түвшинд очсон байна. 2018 оны наймдугаар сард 1100 ам.доллар хүрч унаад байсан алтны ханш энэ оны хувьд харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



"Standard bank" нүүрсний төслүүдийн санхүүжилтийн бодлогыг ил байлгахыг дэмжив

Африк тивийн томоохонд тооцогддог банкнуудын нэг "Standard Bank Group" нүүрсний цахилгаан станц болон нүүрсний уурхайн үйл ажиллагаатай холбоотой төслийн санхүүжилтийн бодлогоо ил танилцуулдаг болох саналыг дэмжлээ.

Өмнөд Африкт төвтэй тус банкны хоёр хувьцаа эзэмшигчийн санаачилгаар энэхүү саналыг хэлэлцсэн байна. Бодлогыг ил танилцуулах саналыг зөвшөөрсөн боловч тус банкны санхүүжилтийн үр дүнд бий болж байгаа хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээг тайлагнадаг байхыг харин "Standard Bank"-ийн гол хувьцаа эзэмшигчид эсэргүүцжээ. Тус банк 2012 оноос хойш эрчим хүчний төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад олгосон санхүүжилтийнхээ 86 хувийг сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд олгосон байна. Олон улсын хэмжээнд лобби бүлгүүд нүүрстэй холбоотой төслүүдээс татгалзах шаардлагыг улам бүр идэвхжүүлж байгаа юм.

Өмнөд Африкийн нүүрсний салбарт 2018 оны байдлаар 86 мянга гаруй хүн ажиллаж байна. Энэ нь тус улсын уул уурхайн салбарын нийт ажиллах хүчний 19 хувь ажээ. Тус улс өнгөрсөн онд нийт 252.6 сая тонн нүүрс олборлосон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Дэлхийн банк 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамгаа 2.6 хувь болгож буурууллаа


Дэлхийн банк 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвөө бууруулж тогтоолоо. Ингэхдээ улс орнуудын худалдааны өсөлт санхүүгийн хямралаас хойших хамгийн доод түвшинд хүрч, хөрөнгө оруулалт буурч байгааг анхаарууллаа.

Тус банк 2019 онд дэлхийн эдийн засгийг гурван хувиар өснө гэсэн тооцооллыг өнгөрсөн онд танилцуулж байсан бол энэ оны эхээр 2.9 хувь болгож бууруулсан юм. Харин мягмар гарагт дахин 2.6 хувь болгож буурууллаа. Харин ирэх онд бага зэрэг сэргэж, 2.7 хувьтай байхаар тооцоолсон байна. Хөгжиж буй зах зээлд бизнесийн итгэл суларч, дэлхийн худалдаа удааширч, хөрөнгө оруулалт саарч байгааг Дэлхийн банкны Ерөнхийлөгч Дэвид Малпасс онцлон анхааруулжээ.

Түүнчлэн АНУ-БНХАУ-ын худалдааны маргаан, хөгжиж буй зах зээлийн санхүүгийн байдал, хөгжингүй орнуудын, ялангуяа Европын орнуудын эмзэг байдал зэрэг нь голлох эрсдэлээр нэрлэгдлээ. Дэлхийн банкнаас жилд хоёр удаа танилцуулдаг “Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв” тайланд мөн бодлогын тодорхойгүй байдал болон голлох эдийн засгуудын худалдааны харилцаа хурцдаж байгаагаас хөрөнгө оруулалт буурч, бизнесийн итгэл суларч байгааг дурдсан байна.

Олон Улсын Валютын Сангийн адилаар Дэлхийн банк АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын худалдааны арга хэмжээг цаашид дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлнө хэмээн таамаглажээ. Дональд Трампын зүгээс Мексикийн цагаачдын тоо буурахгүй бол ирэх долоо хоногоос эхлэн Мексикийн импортын бараа, бүтээгдэхүүнд тариф ногдуулахаар болсон юм. Үүнээс үүдэн Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах магадлалтай хэмээн зарим эдийн засагчид таамаглаж байна

Эх сурвалж: BloombergTv.mn



Монгол улсын борлуулалтын менежерүүдийн индекс өмнөх сараас 0.8 нэгжээр буурч, 56.3 нэгж боллоо

“World Economics” байгууллагаас танилцуулдаг Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс энэ оны тавдугаар сард өмнөх сараас 0.8 нэгжээр буурч, 56.3 нэгж болсон байна.

Хэдий тийм боловч энэ онд ерөнхийдөө 50 нэгжээс дээш буюу өсөлтийн бүсэд хадгалагдаж байгаа юм. Задлаад харвал зах зээлийн өсөлтийн индекс өндөр хэвээр байна. Мөн “Борлуулалтын өсөлтийн индекс зургаан нэгжээр давсан нь эрүүл өсөлтийг илэрхийлж байна” гэжээ. Өөрөөр хэлбэл Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс эдийн засгийн эрчимтэй өсөлт үргэлжилж байгааг илэрхийлж байна гэж “World Economics” дүгнэж байгаа юм. Түүнчлэн “БНХАУ-ын эдийн засгийн эдийн засгийн идэвхжил Монголын зах зээлд эергээр нөлөөлж байгаа” гэж онцолсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Эдийн засгийн өрсөлдөх чадварын тайланг танилцууллаа



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан-2019”-г өнөөдөр “Монгол ньус” мэдээллийн төвд танилцууллаа.

Энэ жил өрсөлдөх чадвараар Сингапур, Хонгконг, АНУ зэрэг улс тэргүүлжээ. Манай хоёр хөрш БНХАУ 14-т, ОХУ 45-т эрэмбэлэгдсэн байна. Манай улсын хувьд, үнэ ханшийн дэд бүлгийн үзүүлэлт хамгийн өндөр буюу дээгүүр гарчээ. Тодруулбал, хэрэглээний үнийн индекс буюу инфляц болон амьжиргааны өртөг, орон сууц, албан байгууллагын түрээс бусад улстай харьцуулахад бага гарсныг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн дэд захирал И.Одончимэг мэдээллээ.

Тэрээр, өрсөлдөх чадварын үндсэн дөрвөн бүлэгт хамгийн дээгүүр эрэмбэлэгддэг эдийн засгийн тамир тэнхээ гэсэн үзүүлэлтээр Монгол Улс 58 дугаарт байгааг хэллээ. Дээрх үзүүлэлтээр манай улс өнгөрсөн жил 48 дугаарт эрэмбэлэгдэж байжээ. Манай улсын өрсөлдөх чадварын оноо өнгөрсөн жилийн хугацаанд буурахад урсгал тэнцэл, ил тод байдал, тэтгэвийн сантай холбоотой үзүүлэлтүүд муудсан нь нөлөөлжээ. Мөн хөдөлмөр эрхлэлт, бизнесийн эрхзүй, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, боловсролын бүлгүүд буурсан нь нөлөөлсөн байна.

“Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-г хэрхэн гаргадаг талаар И.Одончимэгээс тодруулбал, “Манайх Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй 2010 оноос хамтран ажиллаж, Монгол Улсын мэдээллийг бэлтгэн явуулдаг. Үүнд, статистик мэдээллүүд болон бизнес эрхлэгчдээс авсан санал асуулга ордог. Тайланд дэлхийн 63 улсыг харьцуулан нийт 332 үзүүлэлт, 235 шалгуураар өрсөлдөх чадварын индексийг тооцон эрэмбэлдэг юм. 235 шалгуурын 143 нь статистик мэдээлэлд тулгуурлаж, 92 нь санал асуулгаас бүрддэг” гэв.

Тэрээр судалгааны дүнг танилцуулах үеэр энэ онд болон ирэх жил манай улсын хувьд тулгарах сорилтын талаар хэлэхдээ, “Манайд хот, суурин газрын хөрс болон агаарын бохирдол нийгэм, эдийн засаг, иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулж байгааг хүн бүр мэднэ. Энэ нь Монголын хувьд, нэлээн хүнд сорилт болж байна. Нөгөөтэйгүүр манай улс ирэх оноос гадаад өрөө эргэн төлж эхэлнэ.

Энэ нь эдийн засгийн өсөлтөд эрсдэл учруулж болзошгүй юм. Мөн 2020 онд болох УИХ-ын сонгуулийн үеэр улстөрийн тогтворгүй байдал бий болж, төрийн бодлогын залгамж халаагүй байдлыг авчрах магадлалтай. Үүнээс улбаатайгаар гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч магадгүй. Засгийн газрын зардлаас шалтгаалж дотоодын эрэлт нэмэгдсэнээр инфляц өсөж болзошгүй байна” гэв.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.